



**МОНГОЛ-ОРОСЫН
ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН НИЙГЭМЛЭГ
УЛААНБААТАР ТӨМӨР ЗАМЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2025 оны 01 сарын 02 өдөр

Дугаар 4/05

Улаанбаатар хот

**Менежментийн нэгдсэн тогтолцооны
хэрэгжилтийг сайжруулах тухай**

Байгууллагын бодлого, зорилт, тээвэрлэлт үйлдвэрлэлийн үр ашиг, нөөцийн оновчтой хэрэглээг дэмжих, удирдах ажилтны манлайллыг төгөлдөршүүлэх, менежментийн нэгдсэн тогтолцоог тасралтгүй сайжруулах зорилгоор Монгол-Оросын хувь нийлүүлсэн нийгэмлэг “Улаанбаатар төмөр зам”-ын дүрмийн 22 дугаар зүйлийн “а” заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. “Улаанбаатар төмөр зам” хувь нийлүүлсэн нийгэмлэгийн үйл ажиллагаанд менежментийн тогтолцооны олон улсын стандартуудыг хэрэгжүүлэх ажлыг тасралтгүй сайжруулах замын нэгдсэн төлөвлөгөө гаргаж хэрэгжилтэд хяналт тавьж, биелэлтийг улирал бүр Замын удирдлагуудад танилцуулж ажиллахыг Техникийн бодлого, стандартчиллын албаны дарга (С.Мөнх-Алдар)-д үүрэг болгосугай.

2. Менежментийн тогтолцооны олон улсын стандартуудыг нэвтрүүлэн хэрэгжүүлэх ажлыг 2025 онд төлөвлөгөө чиглэл гарган чанартай зохион байгуулахыг бүх алба, хэлтэс, төв, тасаг салбар нэгжийн дарга, дэд тогтолцоо хариуцагч нарт үүрэг болгосугай.

3. “Улаанбаатар төмөр зам” хувь нийлүүлсэн нийгэмлэгийн бүтээгдэхүүн үйлчилгээнд стандартын шаардлагыг хангуулах, баталгаажуулалтын аудитад хамрагдаж гэрчилгээжих, гэрчилгээжсэн бүтцийн нэгжүүд магадлангийн аудитад хамрагдах ажлыг судалгаанд тулгуурлан үе шаттайгаар зохион байгуулахыг, энэ чиглэлээр төрийн захиргааны зохих байгууллагатай хамтран ажиллахыг Техникийн бодлого, стандартчиллын албаны дарга (С.Мөнх-Алдар)-д хариуцуулсугай.

4. Энэхүү тушаалын хэрэгжилтийг хангуулж, хяналт тавьж ажиллахыг Ерөнхий инженер (Бондарь Д.В.) -т үүрэг болгосугай.

ДАРГА



Х.ХЭРЛЭН

1601250004